



ДҮНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/163

Хажуу шинэ-Ус

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэхийг түр хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1 дэх заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архиdan согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны A/436 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах зөөврийн битүүмжилсэн хайрцаар болон санал авах байранд, хяналтын тооллого хийхтэй холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 27, 28, 29-ний өдрийг дуустал хугацаанд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр зогсоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг "Угтаал чандмань хоршоо"-ны дарга (Д.Амгалан), "Угтаал трейд" ХХК захирал (Л.Өлзийбүрэн), "Дэлгэр хонгор" ХХК захирал (М.Эрдэнэбат), "Ажирхай дэвжих хоршоо"-ны дарга (А.Ууганбаяр) нарт даалгасугай.

3. Сонгуулийн санал хураалтын үеэр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд сонсогчдын аюулгүй байдлыг хангаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөлгч (Э.Ванчиндорж), Цагдаа (Б.Наранбаатар), Хүнс хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Д.Сарангэрэл), 4 дүгээр багийн Засаг дарга (Л.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧИЛГЭН
Б.ДАВААСҮРЭН



482401069